



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2021 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 86

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дах заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 62 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3, 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Гурвансайхан суманд барьж ашиглалтад оруулсан, нийт 1,139,470,753 /нэг тэрбум нэг зуун гучин есөн сая дөрвөн зуун далан мянга долоон зуун тавин гурав/ төгрөгийн өртөг бүхий барилга, эд хөрөнгийг Гурвансайхан сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгийн дансанд хавсралтын дагуу бүртгэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр: Гурвансайхан сумын Засаг даргын тамгын газрын дарга (Б.Энхтуяа)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

- 2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;
- 2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;
- 2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2021 оны 05 дугаар сарын  
20-ний өдрийн 16-...тогтоолын хавсралт

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон  
Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын  
газрын үндсэн хөрөнгөд бүртгэх хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн үнэ	Дүн
1	Захиргааны барилга	ш	1	1,113,094,923.00	1,113,094,923.00
2	Бохир усны шугам	м	11	1,003,296.91	11,036,266.00
3	Гадна дулааны шугам	м	10	1,329,716.7	13,297,167.00
4	Гадна цэвэр усны шугам	м	45	45,386.6	2,042,397.00
<b>Барилга байгууламжийн дүн</b>					<b>1,139,470,753.00</b> /нэг тэрбум нэг зуун гучин есөн сая дөрвөн зуун далан мянга долоон зуун тавин гурав/